



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Гурвансайхан сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДУА-2026/21/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Мандалговь хот

2026 он

Аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох

Утас: 70592439

Цахим хаяг: [Munkhtogtokhr@audit.gov.mn](mailto:Munkhtogtokhr@audit.gov.mn)

Аудитын менежер: Т.Батсайхан

Утас: 70592225

Цахим хаяг: [Batsaikhant@audit.gov.mn](mailto:Batsaikhant@audit.gov.mn)

Ахлах аудитор: Ж.Угтахбаяр

Утас: 70593113

Цахим хаяг: [Ugtakhbayarj@audit.gov.mn](mailto:Ugtakhbayarj@audit.gov.mn)

Аудитор: Д.Должинсүрэн

Утас: 70593113

Цахим хаяг: [Doljinsurend@audit.gov.mn](mailto:Doljinsurend@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

.....	0
1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3.1 Төлбөрийн акт .....	10
3.2 Албан шаардлага .....	10
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	0

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС      Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

АДБОУС      Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

## 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум  
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,  
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2026.02.13 № 23

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ГУРВАНСАЙХАН СУМЫН ЗАСАГ  
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  
Г.МӨНХЦЭЦЭГ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Гурвансайхан сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Гурвансайхан сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад Монгол улсын Засгийн газрын шийдвэрээр 2025 оны 01 сарын сарын 01-ээр төрийн албаны үндсэн цалин нэмсэнтэй холбоотой цалингийн зардал өмнөх оноос 35.0 сая төгрөгөөр өссөн байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

#### Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад 2025 оны сүүлээр төсвийн орлогын бүрдэлтэй уялдуулан төсвийг хэмнэлттэй хуваарилж, зарцуулах, төсвийн сахилга батыг чангатгах, төрийн санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор төрийн сангийн дансны гүйлгээний эрхийг хаасантай холбоотой үйл ажиллагааны зардал болон албан томилолтын зардлын гүйлгээнүүдийг хийж амжилгүй 26.1 сая төгрөгийн өр төлбөр үүссэн.

Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

#### Бусад асуудлын хэсэг

4826050078

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 16 зорилт, 43 арга хэмжээг төвлөснөөс гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 92.6 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,191,163.06	891,163.06
312	Банканд байгаа бэлэн мөнгө	2,191,163.06	891,163.06
3121	Төгрөг	2,191,163.06	891,163.06
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	2,191,163.06	891,163.06
33	АВЛАГА	31,524,332.13	28,237,141.46
331	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,214,500.10	624,366.10
335	Бусад авлага	30,309,832.03	27,612,775.36
3351	Байгууллагаас авах авлага	13,241,401.44	20,074,705.36
3352	Хувь хүмүүсээс авах авлага	17,068,430.59	7,538,070.00
35	БАРАА МАТЕРИАЛ	150,318,221.09	158,488,802.00
351	Түүхий эд материал	24,933,865.00	25,508,865.00
3511	Тусгай зориулалттай материал	23,016,350.00	23,591,350.00
3513	Эм боох материал	1,917,515.00	1,917,515.00
354	Хангамжийн материал	125,384,356.09	132,979,937.00
3541	Бичиг хэргийн материал	3,874,000.00	2,855,300.00
3542	Аж ахуйн материал	106,813,375.09	116,916,936.00
3543	Сэлбэг хэрэгсэл	5,164,800.00	4,968,800.00
3545	Барилгын засварын материал	9,532,181.00	8,238,901.00
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	184,033,716.28	187,617,106.52
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,763,440,200.42	6,406,532,788.82
392	Биет хөрөнгө	5,692,291,251.97	6,344,090,633.27
39201	Барилга, байгууламж, орон сууц	7,179,534,174.39	8,238,092,961.32
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,972,572,150.17)	(2,332,139,711.04)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	255,131,709.27	194,631,709.27
39204	Хуримтлагдсан элэгдэл	(96,400,530.82)	(117,588,516.48)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	278,681,431.37	321,067,761.93
39206	Хуримтлагдсан элэгдэл	(57,977,715.25)	(118,354,821.41)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	76,544,382.00	74,350,890.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(24,792,923.58)	(31,038,525.12)
39214	Бусад үндсэн хөрөнгө	54,439,950.00	124,439,950.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(297,075.24)	(9,371,065.20)
393	Биет бус хөрөнгө	71,148,948.45	62,442,155.55
39301	Программ хангамж	5,386,625.00	5,136,625.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(811,654.22)	(1,468,979.30)
39303	Бусад биет бус хөрөнгө	100,727,700.00	100,415,200.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(34,153,722.33)	(41,640,690.15)
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,763,440,200.42	6,406,532,788.82
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,947,473,916.70	6,594,149,895.34
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	12,085,388.02	26,128,390.00
413	Өглөг	12,085,388.02	26,128,390.00
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг		25,676,390.00
4136	Бусад өглөг	12,085,388.02	452,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	12,085,388.02	
41362	Хувь хүмүүст төлөх өглөг		452,000.00
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	12,085,388.02	26,128,390.00
51	Засгийн газрын хувь оролцоо	5,935,388,528.68	6,568,021,505.34
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	479,936,623.37	479,936,623.37
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	479,936,623.37	479,936,623.37
512	Хуримтлагдсан үр дүн	4,665,276,886.10	5,298,391,228.99
5121	Өмнөх үеийн үр дүн	4,665,276,886.10	4,666,661,566.15
5122	Тайлант үеийн үр дүн		631,729,662.84
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	790,175,019.21	789,693,652.98
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,935,388,528.68	6,568,021,505.34
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,947,473,916.70	6,594,149,895.34

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,055,064,089.65	1,454,920,212.18
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	64,869,689.65	77,619,412.18
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,200,000.00	
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		75,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,853,152.00	19,688,717.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	37,816,537.65	57,855,695.18
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	990,194,400.00	1,377,300,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	990,194,400.00	1,377,300,800.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	553,850,174.24	1,187,253,605.95
120	Нийтлэг татварын бус орлого	553,850,174.24	1,187,253,605.95
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	16,154,751.30	9,848,758.95
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,079,214.00	9,848,758.95
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	12,075,537.30	
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	450,515,720.20	1,155,783,827.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	87,179,702.74	21,621,020.00
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,608,914,263.89	2,642,173,818.13
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,538,026,801.11	2,006,716,860.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,419,122,556.54	1,565,485,250.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	520,574,451.77	607,337,489.43
210101	Үндсэн цалин	319,913,969.14	354,892,024.87
210102	Нэмэгдэл	185,609,682.63	219,207,964.56
210103	Унаа хоолны хөнгөлөлт		13,840,000.00
210104	Урамшуулал	15,050,800.00	19,397,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62,033,424.65	69,852,579.10
210201	Тэтгэврийн даатгал	42,582,005.13	48,550,800.15
210202	Тэтгэмжийн даатгал	5,080,114.22	5,866,898.57
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,540,007.64	2,933,449.30
210204	Ажилгүйдлийн даатгал	2,310,340.34	2,580,602.23
210205	Эрүүл мэндийн даатгал	9,520,957.32	9,920,828.85
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	64,820,493.96	78,160,245.74
210301	Гэрэл, цахилгаан	6,494,979.96	15,762,371.74
210302	Түлш, халаалт	56,896,714.00	58,635,874.00
210303	Цэвэр, бохир ус	1,428,800.00	3,762,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	65,284,712.50	52,876,939.09
210401	Бичиг хэрэг	3,212,541.00	5,162,130.00
210402	Тээвэр, шатахуун	23,285,600.00	24,361,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,648,800.00	3,690,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,996,800.00	1,929,050.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,246,412.50	17,733,859.09
210408	Бараа материал акталсны зардал	21,894,559.00	
2105	Норматив зардал	6,986,900.00	
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	730,500.00	
210502	Хоол, хүнс	6,101,400.00	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	155,000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,572,805.00	40,001,830.00
210604	Урсгал засвар	8,572,805.00	40,001,830.00
2107	Томилолт, зочны зардал	19,088,000.00	22,420,000.00
210702	Дотоод албан томилолт	19,088,000.00	22,420,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,309,694.00	106,613,773.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30,299,090.00	105,675,280.00
210803	Даатгалын үйлчилгээ	910,000.00	89,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	162,824.00	189,480.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	680,000.00	450,000.00
210807	Газрын төлбөр	235,780.00	209,913.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	639,452,074.66	588,222,394.27
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	138,050,205.00	73,908,450.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,780,000.00	250,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	499,621,869.66	514,063,944.27
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	118,904,244.57	441,231,610.33
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,407,758.00	86,555,370.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	5,179,900.00	48,840,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		37,715,370.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	22,577,858.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,650,000.00	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	89,496,486.57	354,676,240.33
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	89,496,486.57	354,676,240.33
	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	19,000,000.00	
	Дотоод эх үүсвэрээр	19,000,000.00	
223001	Бусад хөрөнгө	19,000,000.00	
II	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	1,557,026,801.11	2,006,716,860.96
III	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	51,887,462.78	635,456,957.17
225	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	24,973,865.03	3,727,294.33
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	7,054,317.86	3,727,294.33
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	5,834,159.15	
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	12,085,388.02	
IV	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН</b>	(24,973,865.03)	(3,727,294.33)
V	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	26,913,597.75	631,729,662.84

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	479,936,623.37	790,175,019.21	4,638,350,591.68	5,908,470,930.93
Тайлант үеийн үр дүн			26,913,597.75	26,913,597.75
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	479,936,623.37	790,175,019.21	4,665,276,886.10	5,935,388,528.68
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		(481,366.23)	1,384,680.05	903,313.82
Тайлант үеийн үр дүн			631,729,662.84	631,729,662.84
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	479,936,623.37	789,693,652.98	5,298,391,228.99	6,568,021,505.34

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	1,058,304,274.01	1,480,606,194.16
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,002,008.00	8,254,682.95
120	Нийтлэг татварын бус орлого	6,002,008.00	8,254,682.95
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,002,008.00	8,254,682.95
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,002,008.00	8,254,682.95
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	1,052,302,266.01	1,472,351,511.21
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	62,107,866.01	95,050,711.21

131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,200,000.00	
131103	ЗГНХ, ЗДН Хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		75,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,853,152.00	19,688,717.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	35,054,714.01	75,286,994.21
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	990,194,400.00	1,377,300,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	990,194,400.00	1,377,300,800.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,036,159,474.01	1,479,706,194.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,036,159,474.01	1,479,706,194.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	917,255,229.44	1,026,038,917.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	522,224,451.77	607,427,355.43
210101	Үндсэн цалин	321,563,969.14	354,981,890.87
210102	Нэмэгдэл	185,609,682.63	219,207,964.56
210103	Унаа хоолны хөнгөлөлт		13,840,000.00
210104	Урамшуулал	15,050,800.00	19,397,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62,033,424.65	69,852,579.10
210201	Тэтгэврийн даатгал	42,582,005.13	48,550,800.15
210202	Тэтгэмжийн даатгал	5,080,114.22	5,866,898.57
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,540,007.64	2,933,449.30
210204	Ажилгүйдлийн даатгал	2,310,340.34	2,580,602.23
210205	Эрүүл мэндийн даатгал	9,520,957.32	9,920,828.85
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	74,607,554.02	77,147,855.74
210301	Гэрэл, цахилгаан	6,494,979.96	15,762,371.74
210302	Түлш, халаалт	66,683,774.06	58,201,084.00
210303	Цэвэр, бохир ус	1,428,800.00	3,184,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	33,105,000.00	28,108,980.00
210401	Бичиг хэрэг	2,924,300.00	3,734,430.00
210402	Тээвэр, шатахуун	23,285,600.00	16,663,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,648,800.00	3,200,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,996,800.00	1,929,050.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,249,500.00	2,582,200.00
2105	Норматив зардал	1,905,000.00	6,448,584.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		6,448,584.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,905,000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,959,900.00	36,119,250.00
210604	Урсгал засвар	14,959,900.00	36,119,250.00
2107	Томилолт, зочны зардал	19,088,000.00	13,100,000.00
210702	Дотоод албан томилолт	19,088,000.00	13,100,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,308,694.00	105,673,773.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30,298,090.00	104,735,280.00
210803	Даатгалын үйлчилгээ	910,000.00	89,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	162,824.00	189,480.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	680,000.00	450,000.00
210807	Газрын төлбөр	235,780.00	209,913.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	157,023,205.00	82,160,540.20
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	155,243,205.00	81,960,540.20
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,780,000.00	200,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	118,904,244.57	453,667,276.69
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,407,758.00	86,555,370.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	5,179,900.00	48,840,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		37,715,370.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	22,577,858.00	

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,650,000.00	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	89,496,486.57	367,111,906.69
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	89,496,486.57	367,111,906.69
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	22,144,800.00	900,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	25,524,800.00	2,200,000.00
	Дотоод эх үүсвэрээр	25,524,800.00	2,200,000.00
223001	Бусад хөрөнгө	19,000,000.00	
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,524,800.00	2,200,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(25,524,800.00)	(2,200,000.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(3,380,000.00)	(1,300,000.00)
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		2,191,163.06
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		891,163.06

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн
1	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,378,300,800.00	1,030,879,242.62	347,421,557.38
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,377,300,800.00	1,022,624,559.67	354,676,240.33
132001	Орон нутгийн төсвөөс	1,377,300,800.00	1,022,624,559.67	354,676,240.33
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,000,000.00	8,254,682.95	-7,254,682.95
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	8,254,682.95	-7,254,682.95
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,378,300,800.00	1,030,879,242.62	347,421,557.38
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	1,378,300,800.00	1,030,879,242.62	347,421,557.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,378,300,800.00	1,030,879,242.62	347,421,557.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,280,515,000.00	943,023,872.62	337,491,127.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	727,545,900.00	607,427,355.43	120,118,544.57
210101	Үндсэн цалин	319,400,300.00	354,981,890.87	-35,581,590.87
210102	Нэмэгдэл	324,742,700.00	219,207,964.56	105,534,735.44
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,650,000.00	13,840,000.00	9,810,000.00
210104	Урамшуулал	36,038,700.00	19,397,500.00	16,641,200.00
210105	Гэрээт ажлын хөлс	23,714,200.00		23,714,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	93,295,000.00	69,852,579.10	23,442,420.90
210201	Тэтгэврийн даатгал	66,927,100.00	48,550,800.15	18,376,299.85
210202	Тэтгэмжийн даатгал	6,592,000.00	5,866,898.57	725,101.43
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,296,000.00	2,933,449.30	362,550.70
210204	Ажилгүйдлийн даатгал	3,296,000.00	2,580,602.23	715,397.77
210205	Эрүүл мэндийн даатгал	13,183,900.00	9,920,828.85	3,263,071.15
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	71,399,100.00	64,562,325.09	6,836,774.91
210301	Гэрэл, цахилгаан	6,300,000.00	3,176,841.09	3,123,158.91
210302	Түлш, халаалт	61,899,100.00	58,201,084.00	3,698,016.00
210303	Цэвэр, бохир ус	3,200,000.00	3,184,400.00	15,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	36,497,500.00	26,456,980.00	10,040,520.00
210401	Бичиг хэрэг	3,540,000.00	3,734,430.00	-194,430.00
210402	Тээвэр, шатахуун	15,722,500.00	15,011,300.00	711,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,347,000.00	3,200,000.00	1,147,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариугал	9,588,000.00	1,929,050.00	7,658,950.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,300,000.00	2,582,200.00	717,800.00
2105	Нормативт зардал	1,027,000.00		1,027,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,027,000.00		1,027,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	38,800,000.00	10,604,650.00	28,195,350.00

210601	Багаж, техник, хэрэгсэл	19,800,000.00		19,800,000.00
210604	Урсгал засвар	19,000,000.00	10,604,650.00	8,395,350.00
2107	Томилолт, зочны зардал	14,600,000.00	13,100,000.00	1,500,000.00
210702	Дотоод албан томилолт	14,600,000.00	13,100,000.00	1,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	175,800,600.00	76,192,933.00	99,607,667.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	172,866,000.00	75,254,440.00	97,611,560.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,022,600.00	89,100.00	933,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	536,000.00	189,480.00	346,520.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	226,000.00		226,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	605,000.00	450,000.00	155,000.00
210807	Газрын төлбөр	545,000.00	209,913.00	335,087.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	121,549,900.00	76,127,050.00	45,422,850.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	119,349,900.00	75,927,050.00	43,422,850.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,200,000.00	200,000.00	2,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	97,785,800.00	86,555,370.00	11,230,430.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	97,785,800.00	86,555,370.00	11,230,430.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	48,840,000.00	48,840,000.00	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	38,795,800.00	37,715,370.00	1,080,430.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,150,000.00		10,150,000.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Гүйцэтгэл
1	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	95,050,711.21
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	95,050,711.21
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	75,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19,688,717.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	75,286,994.21
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	95,050,711.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	95,050,711.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	82,615,044.85
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,585,530.65
210301	Гэрэл, цахилгаан	12,585,530.65
2104	Хангамж, бараа материалын зардал	1,652,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,652,000.00
2105	Нормативт зардал	6,448,584.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,448,584.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,714,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,200,000.00
210604	Урсгал засвар	25,514,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,480,840.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	29,480,840.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,733,490.20
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,733,490.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,435,666.36
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох	12,435,666.36
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,435,666.36
2	НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	95,050,711.21

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 175,452.5 мянган төгрөгийн зөрчил илэрснээс аудитын явцад 3,740.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,639.6 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 170,072.9 мянган төгрөгийн 5 зөрчлийг арилгах хугацаатай албан шаардлагыг хүргүүлжээ.

**Залруулсан алдаа:**

Аудитаар нийт 3,740.0 мянган төгрөгийн 1 алдаа<sup>1</sup> илрүүлж аудитын явцад бүрэн залруулсан. Үүнд:

- Албан томилолтын зардлыг зориулалт бусаар хавтгайруулан олгохоор 3,740.0 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн;

### **Залруулаагүй алдаа:**

Аудитаар нийт 171,712.5 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрсэнд 2 төлбөрийн акт, 3 албан шаардлага хүргүүлсэн.

## **3.1 Төлбөрийн акт**

**3.1.1** Албан томилолтын зардалтай давхардуулан 210.0 мянган төгрөгийн хоолны мөнгө олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2-т (*батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*), 16.5.5-д (*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*), Засгийн газрын 2019 оны "Төрийн албан хаагчдад нөхөн төлбөр олгох тухай журам"-ын 2.2.-д (*Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараах зардлаас бүрдэнэ: 2.2.3. хоолны зардал*), 8.4-д (*Төрийн албан хаагчийн өдрийн хоолны зардлын тодорхой хэсгийг байгууллагаас нөхөн олгоно*) тус тус заасныг;

**3.1.2** Тамгын газрын даргад нууц хамгаалах чиг үүргийг хариуцуулахдаа тагнуулын байгууллагаас зөвшөөрөл авалгүй 1,429.6 мянган төгрөгийн нууцын нэмэгдэл олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн Төсвийн тухай хуулийн 16.5.2-т (*батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*), 16.5.5-д (*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*), Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журмын 2.1.-д (*Тагнуулын байгууллагын саналыг авсны үндсэн дээр байгууллага өөрийн бүтцэдээ нууц хамгаалах нэгж байгуулах, өөрчлөх, татан буулгах, эсхүл орон тооны ажилтан томилох шийдвэрийг гаргана*) тус тус заасныг зөрчсөн.

## **3.2 Албан шаардлага**

**3.2.1** Түрээсийн авлагыг бүрэн төвлөрүүлж, 4,256.4 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8-д (*өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх*), Төсвийн тухай хуулийн 6.4.8-д (*төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*), 16.5.2-д (*батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*) тус тус заасныг;

**3.2.2** Шатахууны 9,804.7 мянган төгрөгийн зардлын тооцоо бодож, зарцуулаагүй тайлагнасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т (*холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах*) тус хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т (*анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*), Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 390 дүгээр тушаалын 1-р хавсралт тус тус заасныг;

**3.2.3** Хагас жилээр 154,761.8 мянган төгрөгийн хөрөнгийн тооллого хийж, тооцоо бодож баталгаажуулаагүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2-д (*Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*), 20.2.6.-д (*Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах*), Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1-д (*Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч, ерөнхий нягтлан бодогч нь тооллого эхлэхийн өмнө дараах бэлтгэл хангасан байх үүрэгтэй:*),

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

(*өмнөх тооллогоор тайлан тэнцлээс хасахаар шийдвэрлэсэн үндсэн хөрөнгө, түүхий эд материал, бэлэн бүтээгдэхүүн, барааг худалдах, устгах зэргээр бүрэн шийдвэрлүүлж үр дүнг бүртгэлд тусгасан байх*), тус тус заасныг;

### **3.2.4 Ажилтны эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ байгуулаагүй.**

Энэ Төсвийн тухай хуулийн 16.5.2-д (*Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*), Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1-д (*Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч, ерөнхий нягтлан бодогч нь тооллого эхлэхийн өмнө дараах бэлтгэл хангасан байх үүрэгтэй:*), (*өмнөх тооллогоор тайлан тэнцлээс хасахаар шийдвэрлэсэн үндсэн хөрөнгө, түүхий эд материал, бэлэн бүтээгдэхүүн, барааг худалдах, устгах зэргээр бүрэн шийдвэрлүүлж үр дүнг бүртгэлд тусгасан байх*) тус тус заасныг

### **3.2.5 Төсвийн хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авч, төсвийг зориулалт бусаар зарцуулсан**

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2-т (*батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*), 16.5.5-д (*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*), Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8.1-т (*Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно*) тус тус заасныг зөрчсөн.

Аудитаар илрүүлсэн 171,712.5 мянган төгрөгийн зөрчлийн 0.7 хувь буюу 1,250.0 мянган төгрөгийн нийцлийн асуудал, 99.3 хувь буюу 170,462.5 мянган төгрөгийн санхүүгийн аудитын зөрчил илэрсэн байна. Үүнээс завсрын аудитаар илэрсэн 168,822.9 мянган төгрөгийн санхүүгийн аудитын зөрчлийг жилийн эцсийн аудитаар зөрчлийг арилгасан тул санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдах боломжгүй, аудитын дүгнэлтэд нөлөөлөх 1,639.6 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг түвшнээс 39 дахин бага тул “ӨӨРЧЛӨЛТГҮЙ” дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



Ажилтны эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ байгуулаагүй	1				1				
Төсвийн хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авч, төсвийг зориулалт бусаар зарцуулсан	1	1,250.0			1	1,250.0			
Дүн	<b>2</b>				<b>2</b>	<b>1,250.00</b>	-	-	-

**5. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудидад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалтгт ай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ		1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>		<b>1</b>			<b>1</b>			